

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны  
2012оны 02 дугаар сарын 15-ны өдрийн  
34 дүгээр тооолын 2 дугаар Хаасралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: Говь Хувьцаат компани

Хаяг, утас: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн  
гудамж, Өөрийн байр. Утас: 11-343051

Хурал хуралдах огноо, газар: 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагт Өөрийн  
компанийн байранд

Хурал хуралдуулах шийдвэр гаргасан огноо: 2015 оны 05 дугаар сарын 13-ны өдөр

Бүртгэх өдөр: 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер диллерийн  
компанид хүргүүлэх огноо: 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Хүргүүлсэн огноо:

Хурлын баримт бичгийн хуудасны тоо:

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА:

Д.ХҮРЭЛБААТАР

2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

ХҮЛЭЭН АВСАН: БҮРТГЭЛИЙН  
МЭРГЭЖИЛТЭН...../...../.....



МОНГОЛ УЛС  
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

62X

2015. оны 05. сарын 13.-ыг өдөр

Дугаар . 08

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 60, 64, 65 дугаар зүйлийг үндэслэн  
**ТОГТООХ нь:**

1. “Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 06 сарын 26-ны өдрийн 10:00 цагт “Говь” хувьцаат компанийн төв байрны хурлын зааланд хуралдуулсугай. Хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Хүрэлбаатар даргалсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 05 сарын 28-ны өдрөөр тогтоож, хурлын товыг 2015 оны 05 сарын 18, 6 сарын 02-ны өдрүүдэд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2015 оны 05 сарын 21-ний өдрийн дотор брокер диллерийн компаниудад хүргүүлэхээр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралт, хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг 2 дугаар хавсралт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай:

Комиссын дарга: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д. Наранбаатар

Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга,

Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр

СБХ-ийн захирал Г.Сэлэнгэ

6. “Говь” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Д.Наранбаатар-т даалгасугай.

7. Саналын хуудсаар санал авах сүүлчийн өдрийг 2015 оны 06 сарын 22-ны өдрөөр тогтоож, саналын хуудсын агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ЗӨВЛӨЛ

УЛТД0034 2076357

Д.ХҮРЭЛБААТАР

ГИШҮҮД:

Ц. БААТАРСАЙХАН

Д. НАРАНБААТАР

Т.ОДМАА

Ц.ОТГОНБААТАР

ТАКЭШИ КАМБЭ

Д.ГЭРЭЛМАА

ХИДЭО САВАДА

Д. ХУЛАН

“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны  
дугаар сарын 15 -ний өдрийн хурлын  
15 -р тогтоолын 1 дүгээр хавсралт

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Компаний дүрэмд оруулах өөрчлөлтийг хэлэлцэн батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох. Үүнд:

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

1. Дамбийжавын ХҮРЭЛБААТАР

2. Такеши КАМБЭ

3. Түнрэвийн ОДМАА

4. Дамбын ГЭРЭЛМАА

**ТУЗ-ийн ердийн гишүүн**

1. Цагаачийн БААТАРСАЙХАН

2. Дашидаваагийн ХУЛАН

3. Хидео САВАДА

4. Даваагийн НАРАНБААТАР

5. Цагаачийн ОТГОНБААТАР нийт 9 гишүүн болно.

“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны  
06 дугаар сарын 13-ний өдрийн хурлын  
08.-р тогтоолын 2. дүгээр хавсралт

**Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж  
болов бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай  
танилцаж болох газар, хугацаа**

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2015 оны 05 сарын 18-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09.30-17.00 цагийн хооронд “Говь” ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн байранд ирж танилцаж болно.
2. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга

“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны  
05 дугаар сарын 26-ний өдрийн хурлын  
08-р тогтоолын 05 дүгээр хавсралт

## “ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 06 сарын 26-ны өдрийн 14 цагт “Говь” ХК-ийн хурлын танхимд болно. Бүртгэх өдөр 2015 оны 5\* дугаар сарын 28-ны өдөр. Хувьцаа эзэмшигч та бухэн 05 дугаар сарын 23-ны өдрөөс брокер дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцана уу.

### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг хэлэлцэн батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2014 оны 05 дугаар сарын 18-ний өдрөөс эхлэн 6 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдэд 09.30-17.00 цагийн хооронд “Говь” ХК-ийн төв байранд байрлах Хуулийн зөвлөхтэй ирж танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс харилцдаг брокер, диллерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцсан, саналын хуудсаа бөглөж, брокер, диллерийн компанидаа эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2015 оны 6 сарын 22-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

### Холбоо барих:

Хурал зохион байгуулах комиссын дарга Утас: 11-3343051

Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Утас: 11-343051(1226), 98118891

И-мэйл: tsaschikher@gobi.mn

### “Говь” ХК-ийн албан ёсны хаяг, байршил:

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,

Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК

Утас: 341193, Факс: 343081

ОВИ  
СТК  
ЭӨ  
ТРД  
ЗЛ  
1526  
34-8

“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны  
05 дугаар сарын 26-ний өдрийн хурлын  
08-р тогтоолын 07 дүгээр хавсралт

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....  
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистерийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо ..... Кумулятив саналын тоо.....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани / .....  
Брокерийн овог ..... нэр .....

“ГОВЬ”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагт ХУД-ийн 3 дугаар хороо компанийн өөрийн байранд болно.

Батлах асуудлууд:

Зөвшөөрсэн      Татгалзсан      Түдгэлзэн

1. Компанийн дүрэмд оруулах  
еөрчлөлтийг батлах

Хувьцаа эзэмшигч саналын хуудсыг бөглөхдөө саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсэн бол зөвшөөрсэн гэсэн нүдэнд (✓), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина

2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
Ердийн トイшүүд		
1 Цагаачийн БААТАРСАЙХАН		
2 Дашибааын ХУЛАН		
3 Хидео САВАДА		
4 Даваагийн НАРАНБААТАР		
5 Цагаачийн Отгонбаатар Хараат бус гишүүд		
1 Дамбийжавын ХҮРЭЛБААТАР		
2 Такеши КАМБЭ		
3 Түнрэвийн ОДМАА		
4 Дамбын ГЭРЭЛМАА		

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үргүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшидэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд. Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхдөө нийт 900 саналын эрхтэй /100\*9гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хуртал нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хуртэл нэр дэвшигчид тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалытай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
- Засварласан болон балласан, заплуулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх талаарх мэдээллийг 98118891 утсаар лавлаж асууна уу.



МОНГОЛ УЛС  
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021. оны 05. сарын 18.-ыг өдөр

Дугаар .09.

Улаанбаатар хот

*Toollogojin komiss batlaah tухай*

«Говь» хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Говь хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга:	Д.Тэгшжаргал – Хүний нөөцийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	С.Цэрэнчимэд – Нягтлан бодогч
Гишүүд:	Г.Золзаяа – Нягтлан бодогч
	3.Цэрэнпүрэв – Хүний нөөцийн менежер

2. Тооллогын комисс (Д.Тэгшжаргал)-д даалгах нь:

- a. хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
- b. хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
- c. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултанд тайлбар өгөх;
- d. санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
- e. саналын хуудсыг хайрцагаар авах;
- f. саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
- g. саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах



ТУЗ-ЫН ДАРГА

ГИШҮҮД:

Д.ХҮРЭЛБААТАР

Ц.БААТАРСАЙХАН

Д.НАРАНБААТАР

Т.ОДМАА

Ц.ОТГОНБААТАР

Түүхийн  
Хувьцаат  
Компани

ТАКЭШИ КАМБЭ

Д.ГЭРЭЛМАА

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН



МОНГОЛ УЛС  
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2015. оны 05 сарын 13-ыг өдөр

Дугаар 10.

Улаанбаатар хот

*Редакцийн комисс томилох тухай*

Говь хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Говь хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын редакцийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга: Ц.Цасчихэр – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Хуулийн зөвлөх

Гишүүд: Б.Мөнхцэцэг – Бизнес төлөвлөлтийн менежер

2. Редакцийн комисс (Ц.Цасчихэр)-т даалгах нь:

- a. Хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг тусган найруулах;
- b. Хурлаас гарах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдээлж батлуулах.

ТУЗ-ЫН ДАРГА

ГИШҮҮД:



Д.ХҮРЭЛБААТАР

Ц.БААТАРСАЙХАН

Д.НАРАНБААТАР

Т.ОДМАА

Ц.ОТГОНБААТАР

ТАКЭШИ КАМБЭ

Д.ГЭРЭЛМАА

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

**ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ**

2015 оны 05 дугаар сарын 13-ны өдөр, Пүрэв гараг

Эхлэх цаг: УБ 09:00 цагт

1. Говь ХК-ийн өнөөгийн байдлын талаар / 2015 оны 4 сарын санхүү, үр дүн. / Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан танилцуулна.
2. Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг гаргаж, тооллогын болон редакцийн комиссыг томилох
3. Компаний 2015 оны Түүхий эд бэлтгэлийн явц
4. Говь ХК-ийн ТҮЗ-ийн үйл ажиллагааг санал асуулгын хуудсаар дүгнэх /Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Гэрэлмаа/
5. Амёб менежментийн явцыг танилцуулах
6. Хурал тарах

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗАРЛАХ АСУУДЛЫГ  
ШИЙДВЭРЛЭХ**

д/д	Шийдвэрлэх асуудлууд	Хуулийн зөвлөхийн санал	Тайлбар
1	Ээлжит бус хурал явуулах аргыг сонгох 1. Хуралдаан 2. Эчнээ санал хураалт	2015.04.16-ны өдрийн ээлжит хурлаар ТҮЗ-ийн бүрэн эрх баталгаажаагүй тул хурлыг Хуралдаанаар явуулж шийдвэрлэх	Нээлттэй хувьцаат компаниудад эчнээ санал хураалтаар явуулж байсан туршлага байхгүй, саналын хуудсыг тараах хүргэх зэрэг үйл ажиллагааны талаар хууль, журамлсан байдал дутмаг тул хуралдаанаар шийдвэрлэх нь зүйтэй.
2	Хурал хуралдуулах, газар, өдөр, цаг	Говь ХК-ийн байранд 2015.06.17-ноос хойш	2015.06.26-ны өдрийн 10 цагт хийх саналтай.
3	Хурлын хэлэлцэх асуудал	1. ТҮЗ-ийн гишүүдийг сонгох Кумулятив аргыг хэрэглэхээр дүрэмд өөрчлөлт оруулах 2. ТҮЗ-ийн гишүүдийг сонгох	2014.06.05-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр Кумулятив аргаар сонгохоор өөрчлөлт орсон тул дүрэмд зайлшгүй өөрчлөлт оруулна
4	Хуралд оролцох ХЭ-ийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр	2015.05.27-ны өдөр	Хуулиар нийтэд зарласан өдрөөс хойш 10 дахь өдөр
5	Хурал хуралдуулах тухай ХЭ-дэд мэдэгдэх, өдөр журам	2015.05.17-ны өдөр	Хурлын шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор
6	ХЭ-дэд танилцаж болох баримт бичгийн жагсаалт	ТҮЗ-ийн гишүүдийн танилцуулга	ТҮЗ-ийн 9 гишүүний товч танилцуулга
7	Хурлын дарга	ТҮЗ-ийн дарга	
8	Тооллогын комиссын дарга, гишүүд	2015.04.16-ны өдрийн Хурлын Тооллогын болон редакцийн комиссын бүрэлдэхүүнийг дахин томилох	

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Хүсэлт гаргах тухай

2015.05.05

“Говь” ХК-ийн ердийн гишүүн Д.Хулан миний бие компанийн 122,473 ширхэг хувьцааг өөрийн нэр дээр эзэмшдэг билээ.

Тус компанийн 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ЭФ-СИ-АЙ ХХК /2,230,019 ширхэг хувьцаатай/, Таван богд трейд ХХК /1,239,796 ширхэг хувьцаатай/, Үлэмж Их ХХК /438,829 ширхэг хувьцаатай/ компаниудын өмнөөс миний бие итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож хурлын хэлэлцэх асуудалд заагдсан саналыг бөглөсөн. Тухайн өдөр санал хураалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс өөрийн нэрийг татгалзсан шийдвэрийг өгсөн бөгөөд өөрийнхөө оронд шинэ хүнийг нэр дэвшүүлж үйл ажиллагааг нь хөндлөнгөөс удирдуулах зорилготой байсан.

Гэвч “Говь” ХК-ийн цаашдын хөгжил дэвшил, тогтвортой үйл ажиллагааг хянаж ажиллуулахын тулд миний бие дахин Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр ажиллах хүсэлтэй байна.

Иймд хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү.

Хүсэлт гаргасан: Хувьцаа эзэмшигч

Д.Хулан

ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗ, СОНИН, РАДИОГООР ДАМЖУУЛАХ  
ЗАРЫН МЭДЭЭЛЭЛ

“Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагт “Говь” ХК-ийн хурлын танхимд болно. Бүртгэх өдөр 2015 оны 2 дугаар сарын 28-ны өдөр. Хувьцаа эзэмшигч та бүхэн 5 дугаар сарын 23-ны өдрөөс брокер дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцана уу.

**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Компанийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдэд 09.30-17.00 цагийн хооронд “Говь” ХК-ийн төв байранд ирж Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргатай уулзан танилцаж болно.

Саналын жуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс харилцаг брокер, диллерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцсан, саналын хуудсаа бөглөж, брокер, диллерийн компанидаа эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2015 оны 6 сарын 22-ны өдрөөс өмнө ируулнэ уу.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

**Холбоо барих:** Утас: 343051 (1226), 98118891 И-мэйл: tsaschikher@gobi.mn

**“Говь” ХК-ийн албан ёсны хаяг, байршил:**

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,  
Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК  
Утас: 3413051, Факс: 343081



#### MONGOLIAN CASHMERE

"Говь" хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагт "Говь" ХК-ийн хурлын танхимд болно. Бүртгэх өдөр 2015 оны 2 дугаар сарын 28-ны өдөр. Хувьцаа эзэмшигч та бүхэн 5 дугаар сарын 23-ны өдрөөс брокер дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцана уу.

#### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдэд 09.30-17.00 цагийн хооронд "Говь" ХК-ийн төв байранд ирж Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргатай уулзан танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс харилцаг брокер, диллерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер, диллерийн компанидаа эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2015 оны 6 сарын 22-ны өдрөөс ёмнө ирүүлнэ үү.

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Холбоо барих утас: 343051 (1226), 9811 8891  
И-мэйл: tsaschikher@gobi.mn

"Говь" ХК-ийн албан ёсны хаяг, байршил:  
Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг,  
3-р хороо, Үйлдвэрийн гудамж, "Говь" ХК  
Утас: 3413051, Факс: 343081